

ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
БАТБАЯР ОВОГТОЙ ГАНБАЯРЫН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР


2020.07.24

Сонгуулийн уриа: Аз жаргалтай гэр бүлийн төлөө ХАМТДАА

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан ба хэрвээ ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх зорилтот ажлууд мөн тухайн нэр дэвшигчийн нэр дэвших баг дээр хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх зорилтуудыг 2 хэсэгт багтаан томъёолж өгсөн болно.

1.Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.


- 1.1. Орон нутгийн хөнгөн /өрхийн/ болон жижиг дунд бизнес эрхлэгчийн зах зээлийг тэлэх замаар дэмжлэг үзүүлнэ. ЖДҮ-ийн сан болон бусад сангуудын мэдээлэл үйл ажиллагааг ил тод хүртээмжтэй болгоно.
- 1.2. Эрдэнэт хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа томоохон аж ахуйн нэгжүүдтэй гурвалсан гэрээ байгуулж үйлдвэрлэл эрхлэгчдийн чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг нэн түрүүнд худалдан авах нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.3. Мал, малын гаралтай түүхий эдийг бэлтгэн боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах нэгдсэн тогтолцоог бий болгоно.
- 1.4. Хагас боловсруулсан бүтээгдэхүүн болон төмөр, зэсийн хүдрээр эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 1.5. Эрдэнэт хотын иргэд байгалийн баялагтаа эзэн байх,үр шимийг нь хүртдэг байх талаар Эрдэнэт хотоос УИХ-д сонгогдсон гишүүдтэй хамтран ажиллаж, эрх зүйн орчинг нь бүрдүүлнэ.
- 1.6. Ажил хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангах, ажлын байр олноор бий болгох тал дээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.7. Иргэдийн амьжиргааг дэмжих, бага орлоготой иргэдэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулж өөрсдийнх нь оролцоог хангаж хэрэгжүүлнэ.
- 1.8. Эрдэнэт хотын захиргаа, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд байгаль орчны бохирдол хүн, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй



A large, stylized handwritten signature in black ink, located to the right of the official stamp.

асуудлууд, гол ус, хөрсний бохирдол, Цагаан тоосыг арилгах тал дээр онцгой анхаарч ажиллана.

- 1.9. Анги дүүргэлт өндөртэй цэцэрлэг, сургуулийн ачааллыг бууруулна.
- 1.10. Цэцэрлэг сургуулийн орчны гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагч хийнэ.
- 1.11. Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 1.12. Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх буюу орчин үед эрэлттэй мэргэжил, инженерчлэлийн чиглэлийн дугуйланг дэмжих, үр дүнд суурилсан санхүүжилтын аргачлалыг нэвтрүүлж, хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэн тэдгээрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.13. Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Медипас зэрэг иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй эмнэлэгүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах, зайлшгүй техник, тоног төхөөрөмжөөр хангах, эмч эмнэлэгийн ажилтнуудыг давтан сургах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэд саадгүй түргэн шуурхай авч байх тал дээр анхаарч ажиллана.
- 1.14. Иргэдэд анхан шатны эмнэлэгийн тусламж үзүүлдэг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг зориулалтын байр, техник, тоног төхөөрөмжтэй болгоход онцгой анхаарч үе шаттай шийдвэрлэн, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг хурдан шуурхай, хүртээмжтэй болгоно.
- 1.15. Гэр хороололд амьдарч буй иргэдэд агаар хөрсний бохирдлыг арилгах тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор цэвэр, бохирын шугам, халаалтын асуудлыг шийдвэрлэх чиглэлээр УИХ, ЗГ, холбогдох яамд, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж эхлүүлнэ. Хогны менежментийг сайжруулж, хог боловсруулах үйлдвэрийг дэмжиж ажиллана.
- 1.16. Гэр хорооллын асфальтан болон сайжруулсан авто болон явган замыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, орон сууцны хорооллуудын авто зам, зогсоол, явган замыг өргөтгөж, зохион байгуулалтыг сайжруулж, нэвтрүүлэх чадавхийг дээшлүүлнэ.
- 1.17. Эрүүл зөв хэрэглээг дэмжих зорилгоор хотын төв болон бусад хэсэгт дугуйн замтай болох ажлыг эхлүүлж мэргэжлийн байгууллагаар зураг төсөл, холбогдох судалгааг хийлгэж, эхлүүлнэ.
- 1.18. Нийтийн тээврийн үйлчилгээний менежментийг сайжруулж, тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх тал дээр анхаарна. Хот хоорондын зорчигч тээврийн Авто вокзалтай болох асуудлыг холбогдох чиглэлээр нь хамтран хэрэгжүүлнэ.




A handwritten signature in blue ink, located to the right of the official stamp.

- 1.19. Нийтийн биеийн тамир, спортыг дэмжих хүрээнд үйл ажиллагаа явуулж буй клубүүд, спортын холбоодын зохион байгуулалтыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.20. Хүүхэд багачууд чөлөөт цагаа өнгөрөөх, чийрэгжүүлэх тоглоомын талбайг хотын төвийн болон гэр хорооллын багуудаар үргэлжлүүлэн хийнэ.
- 1.21. Хотын ДЦС-ын өргөтгөл хийгдэж, Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нэмэгдэж байгаатай холбогдуулан хотын хуучирсан инженерийн шугам сүлжээг үе шаттай солих ажлыг эрчимжүүлнэ.
- 1.22. Ахмад, Эмэгтэйчүүд, Залуучууд, Хүүхдүүд рүү хандсан нийгмийн харилцааг зохицуулах, дэмжсэн дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлнэ. Өндөр настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү хандсан нийгмийн дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх тал дээр онцгойлон анхаарч ажиллана.
- 1.23. Орон нутгийн дотоод зах зээлээ хамгаалах, хүнс, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдалд онцгой анхаарч эрх зүйн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.24. Эрдэнэт хотыг үер усны болзошгүй аюулаас хамгаалах үерийн хамгаалалтын далан барих асуудалд онцгой анхаарч дэмжиж ажиллана.
- 1.25. Хотын иргэдийн аюулгүй байдалд анхаарч камержуулалтын системийг төгөлдөржүүлэх, хууль сахиулах онцгой чиг үүрэг бүхий байгууллагуудыг шаардлагатай техник хэрэгслээр дэмжиж, бэлэн байдлыг хангуулахад хамтран ажиллана.
- 1.26. Орхон аймаг нь Эрдэнэт хот болж байгаатай уялдуулан нийгэмд үйлчилдэг ТББ-уудтай хамтран улсын хэмжээнд эелдэг, соёлч, боловсон хот болгоно.
- 1.27. Төрийн үйлчилгээний соёлийг төгөлдөржүүлэн, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээг хүртээмжтэй, хурдан шуурхай болгох ажлыг зохион байгуулна.

2. Багийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.


- 2.1 Гэр хорооллын инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлж, үе шаттайгаар гудамж бүрийг холбох ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.2 Айл өрхийн гэр, байшингийн дулаан алдагдлыг багасгах ажлыг мэргэжлийн байгууллага, иргэдтэйгээ хамтран зохион байгуулна.
- 2.3 Мэргэжлийн байгууллагуудаар иргэдийнхээ амьжиргааны түвшин, ам бүлд тохирсон дулаан, тохилог байшингийн загвар гарган шинээр барих ажлыг иргэдтэйгээ хамтран зохион байгуулна.
- 2.4 Багийн нутаг дэвсгэр дээрх үерийн ус зайлуулах шугамын ажлыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.



- 2.5 Багийн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг багийн ЗД-ын ажлын алба, Цагдаагийн хэсэг, Өрхийн эмнэлэгийн ажиллах нөхцлийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэдэг зохицуулалтыг бий болгоно.
- 2.6 Багийн хэмжээнд ахмад настны хөгжлийн төв, залуусын чөлөөт цагийн төв, нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх төв, эцэг эхчүүд гэр бүлд зориулсан төв байгуулах зэрэг аливаа үүсгэл санаачлагыг дэмжиж ажиллана.
- 2.7 Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж бодлогоор дэмжинэ.
- 2.8 Багийн харьяалал бүхий ажил хөдөлмөр идэвхитэй хайж байгаа иргэдэд туслах зорилго бүхий Хөдөлмөрийн бирж ажиллуулах бодлого зохицуулалт хийнэ.
- 2.9 Багийн нутаг дэвсгэрт буй ногоон байгууламжийг арчилж тордох, цаашид үе шаттай нэмэгдүүлж, багийн иргэд хашаандаа тарьж ургуулах боломжийг нээж өгнө.
- 2.10 Багийн нутаг дэвсгэр дэх сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр байнга анхаарч ажиллана.
- 2.11 Ахмад настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандуулах нийгмийн бүхий л дэмжлэгийг чирэгдэлгүй хүргэх ажилд онцгой анхаарна.
- 2.12 Багийн хэмжээнд хотын соёлыг түгээх, соён гэгээрүүлэх ажлуудыг иргэдийн шууд оролцоотойгоор өргөн хүрээнд зохион байгуулна.
- 2.13 Багийн иргэдийн оролцоог дэмжих замаар цэвэрч, дэгжин хашаатай баг болох ажлыг эхлүүлнэ.

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан

Бие даан нэр дэвшигч.....Б.Ганбаяр



A handwritten signature in blue ink, appearing to be 'Б.Ганбаяр', located at the bottom right of the page.